



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/356

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр зөвлөмжийн дагуу Баянтээг хувьцаат компанид хүнд даацын авто машин нийлүүлэх тендерийн 1 дүгээр багц Өөрөө буулгагч авто самосвал машиныг 596.000.000 (таван зуун ерэн зургаан сая) төгрөгөөр Нутгийн буян групп, 2 дугаар багц Автогрейдер машиныг 248.500.000 (хоёр зуун дөчин найман сая таван зуун мянга) төгрөгөөр Нисээч интернэшнл ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг Баянтээг хувьцаат компани (О.Сумъяасүрэн)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Баянтээг хувьцаат компаний санхүүч (Ю.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100572